



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/46

Булган сум

Жендэрийн салбар хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 29 дүгээр зүйлийн 29.2, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор баталсан Жендэрийн үндэсний хорооны дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын бичиг баримт, хөгжлийн хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих, жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар зөвлөлдөх чиг үүрэг бүхий аймгийн жендэрийн салбар хороог шинэчлэн байгуулсугай.

2. Салбар хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Аймгийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр тухайн жилд хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд тусгуулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг жендэрийн салбар хорооны дэд дарга (Засаг даргын орлогч)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны А/498 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
01 дүгээр сарын 12-ны/ний өдрийн 4/16 дүгээр
захирамжийн хавсралт

Жендэрийн салбар хорооны бүрэлдэхүүн

Салбар хорооны дарга:

Аймгийн Засаг дарга

Салбар хорооны дэд дарга:

Аймгийн Засаг даргын орлогч дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,

төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн

бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн

бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын

хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх

зүйн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-

шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Статистикийн хэлтсийн дарга

Цагдаагийн газрын дарга

Боловсролын газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын

дарга

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн

нарийн бичгийн дарга

Хүний эрхийн Үндэсний комиссын орон нутаг дахь

төлөөлөл

Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрлэлийн

танхимын Булган аймаг дахь салбарын төлөөлөл

Либерал эмэгтэйчүүдийн оюуны сангийн Булган

аймаг дахь салбарын төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн

бодлогын хэлтсийн Жендэрийн асуудал

хариуцсан мэргэжилтэн